

УВС АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайлан

Аудитын код: УВА-2023/50/НА-СТА-ТШЗ

Цахим хуудас:
www.audit.mn

Улаангом хот
2023 он

Увс аймаг дахь Төрийн аудитын газар,

Дарга, тэргүүлэх аудитор: М.Батсуурь

Утас: 70453317, Цахим хаяг:
BatsuuriM@audit.gov.mn

Аудитын менежер: М.Бат-Амгалан

Утас: 70453799, Цахим хаяг: Bat-Amgalanm@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Авирмэд

Утас: 70453799, Цахим хаяг: AvirmedB@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.



АГУУЛГА

1. Хараат бус аудиторын дүгнэлт.....	3
2. Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	5
3. Санхүүгийн тайлангийн тодруулга.....	11
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа.....	11
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин.....	11
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	12
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлт.....	12
4. Аудитын тайлан.....	14
4.1 Ерөнхий зүйл	14
4.2 Материаллаг байдал	15
4.3 Төрийн хэмнэлтийн хуулийн хэрэгжилт.....	15
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	15
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	16
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	16
5. Аудитын илрүүлэлт	16

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн өмчийн бодлого зохицуулалтын газар





**УВС АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

213400, Увс аймаг, Улаангом сум,
Ө.Бадрахын гудамж
Утас: 70-45-33-17, Факс: (976)70-45-33-17,
E-mail: uvs@audit.gov.mn

2023.02.08 № 28А-2023/50/НА-СТА-ЦЦЗ
танай _____-ны № _____-т

ОНЦГОЙ БАЙДЛЫН ГАЗРЫН
ДАРГА, ХУРАНДАА Б.БАТТУЛГА
ТАНАА

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

Монгол Улсын Засгийн газар, ОХУ-ын Засгийн газар хоорондын хэлэлцээрийг хэрэгжүүлэх ажлын хүрээнд Онцгой байдлын ерөнхий газар, ОХУ-ын Онцгой байдлын яамны Бүгд Найрамдах Тува Улс дахь Ерөнхий газар хоорондын "Гамшгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх, тэдгээрийн үр дагаврыг арилгах талаар 2023 онд хамтран ажиллах төлөвлөгөө"-г батлах ажлын уулзалтыг Увс аймгийн Онцгой байдлын газарт зохион байгуулж, арга хэмжээнд Ховд, Увс, Завхан, Хөвсгөл, Баян-Өлгий аймгийн Онцгой байдлын газрын удирдлага, төлөөллүүд оролцжээ.

Аудитын гол асуудал

АДБОУС 2701.8-д тодорхойлсон тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад үлэмж нөлөө үзүүлэх ажил гүйлгээ байхгүй болно.

Бусад асуудлын хэсэг

Санхүүгийн тайлангийн тодруулга толилуулгад тусгаагүй, аудитын хамрах хүрээний хязгаарлалтын улмаас аудитын хангалттай, зохистой нотолгоог олж авах боломжгүй асуудал гараагүй болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



М.БАТСУУРЬ

2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Код	Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,055,526,437.84	1,249,549,124.53
35	БАРАА МАТЕРИАЛ	1,055,526,437.84	1,249,549,124.53
35100	Түүхий эд материал	704,770,758.85	834,852,524.73
35110	Тусгай зориулалттай материал	704,150,758.85	834,102,524.73
35130	Эм боох материал	620,000.00	750,000.00
35400	Хангамжийн материал	338,130,678.99	401,381,599.80
35410	Бичиг хэргийн материал	560,955.00	1,440,380.00
35420	Аж ахуйн материал	330,192,723.99	378,645,219.80
35430	Сэлбэг хэрэгсэл	7,377,000.00	21,296,000.00
35600	Мал амьтад	12,625,000.00	13,315,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	6,724,014,079.63	6,149,957,218.68
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	6,724,014,079.63	6,149,957,218.68
39200	Биет хөрөнгө	5,745,161,879.67	5,170,973,018.76
39201	Барилга, байгууламж, орон сууц	3,788,905,454.00	3,825,556,151.00
39202	Хуримтлагдсан элэгдэл	-541,273,051.58	-622,846,797.73
39203	Авто-тээврийн хэрэгсэл	5,091,136,773.33	5,146,436,213.33
39204	Хуримтлагдсан элэгдэл	-2,647,884,879.75	-3,250,085,186.73
39205	Машин тоног төхөөрөмж(компьютер)	134,257,036.51	189,298,836.51
39206	Хуримтлагдсан элэгдэл	-83,290,685.19	-119,309,629.29
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	9,693,706.64	9,693,706.64
39208	Хуримтлагдсан элэгдэл	-6,382,474.29	-7,770,274.97
39300	Биет бус хөрөнгө	978,852,199.96	978,984,199.92
39301	Программ хангамж	1,200,000.00	1,200,000.00
39302	Хуримтлагдсан элэгдэл	-488,000.04	-844,000.08
39303	Бусад биет бус хөрөнгө	978,140,200.00	978,628,200.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	7,779,540,517.47	7,399,506,343.21
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	0.00	22,204,782.00
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	0.00	22,204,782.00
41300	Өглөг	0.00	22,204,782.00
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	0.00	22,204,782.00
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	7,779,540,517.47	7,377,301,561.21
51	Засгийн газрын хувь оролцоо	7,779,540,517.47	7,377,301,561.21
51100	Засгийн газрын оруулсан капитал	1,543,338,689.60	0.00
511001	Улсын төсвийн оруулсан хөрөнгө	1,543,338,689.60	0.00
51101	Өмч /төрийн/ /ТӨҮГ/	0.00	1,543,338,689.60
51200	Хуримтлагдсан үр дүн	5,692,436,091.71	5,290,197,135.45
51210	Өмнөх үеийн үр дүн	5,212,895,574.45	5,692,436,091.71
51220	Тайлант үеийн үр дүн	479,540,517.26	-402,238,956.26
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	543,765,736.16	543,765,736.16
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	7,779,540,517.47	7,399,506,343.21

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	3,786,325,933.55	2,789,546,371.97
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	1,383,971,410.55	517,505,167.97
120	Нийтлэг татварын бус орлого	1,383,971,410.55	517,505,167.97
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	152,065,800.00	28,230,813.97



1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	152,065,800.00	28,230,813.97
120017	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө	1,078,120,000.00	119,800,000.00
120018	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Бараа материал	153,785,610.55	369,474,354.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,402,354,523.00	2,272,041,204.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,113,394,500.00	2,088,783,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,113,394,500.00	2,088,783,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	288,960,023.00	183,257,304.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,187,500.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	255,878,023.00	40,105,039.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,789,500.00	142,977,265.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00	175,000.00
II	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	3,306,785,416.29	3,191,785,328.23
21	УРСГАЛ ЗАРДАЛ	3,306,785,416.29	3,191,785,328.23
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	3,283,458,330.29	3,178,067,271.23
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,668,756,845.00	1,694,937,723.00
210101	Үндсэн цалин	1,160,450,345.00	982,910,223.00
210102	Нэмэгдэл	478,086,300.00	667,477,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	30,220,200.00	44,550,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,821,767.00	53,642,000.00
210201	Тэтгэврийн даатгал	11,257,028.00	13,833,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,374,500.00	1,627,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,099,600.00	1,301,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	359,439.00	325,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,731,200.00	36,553,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	156,169,219.00	173,515,882.00
210301	Гэрэл, цахилгаан	20,008,916.00	15,854,127.00
210302	Түлш, халаалт	134,455,657.00	155,713,959.00
210303	Цэвэр, бохир ус	1,704,646.00	1,947,796.00
2104	Хангамж, бараа материалын зардал	141,907,713.55	126,359,095.00
210401	Бичиг хэрэг	11,484,155.00	6,446,925.00
210402	Тээвэр, шатахуун	122,622,410.55	112,276,140.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,912,548.00	4,155,230.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,888,600.00	3,480,800.00
2105	Нормативт зардал	166,940,654.45	131,284,294.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,250,200.00	1,205,100.00
210502	Хоол, хүнс	69,208,000.00	67,993,000.00
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	94,482,454.45	62,086,194.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	99,971,100.00	122,525,907.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	385,400.00	0.00
210604	Урсгал засвар	99,585,700.00	122,525,907.00
2107	Томилолт, зочны зардал	115,485,500.00	37,644,000.00
210702	Дотоод албан томилолт	115,485,500.00	37,644,000.00

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	16,965,077.00	17,778,447.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,163,000.00	813,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,693,900.00	1,693,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	893,704.00	1,095,676.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	638,000.00	649,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,667,200.00	1,667,200.00
210807	Газрын төлбөр	6,102,873.00	11,052,971.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	867,440,454.29	820,379,923.23
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	102,391,090.00	30,744,948.31
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	300,000.00	4,720,500.00
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	764,749,364.29	784,914,474.92
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,327,086.00	13,718,057.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,053,304.00	10,034,309.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,053,304.00	10,034,309.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,273,782.00	3,683,748.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,225,631.00	3,683,748.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	48,151.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (III)=(I)-(II)	479,540,517.26	-402,238,956.26
VI	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ НИЙТ ҮР ДҮН (VI)=(III)+(IV)-(V)	479,540,517.26	-402,238,956.26

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Код	Үзүүлэлт	ӨМНӨХ ОН	ТАЙЛАНТ ОН
I	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (I)	2,402,354,523.00	2,272,041,204.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	2,402,354,523.00	2,272,041,204.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	2,113,394,500.00	2,088,783,900.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	2,113,394,500.00	2,088,783,900.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	288,960,023.00	183,257,304.00
131101	Төрийн болон орон нутгийн өмчит бус этгээдээс авсан хандив, тусламж	4,187,500.00	0.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	255,878,023.00	40,105,039.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	28,789,500.00	142,977,265.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	105,000.00	175,000.00
II	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,327,334,723.00	2,202,199,404.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,327,334,723.00	2,202,199,404.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,304,007,637.00	2,186,081,347.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,668,756,845.00	1,695,037,723.00
210101	Үндсэн цалин	971,016,045.00	983,010,223.00
210102	Нэмэгдэл	657,447,800.00	667,477,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	40,293,000.00	44,550,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	49,771,928.00	54,242,000.00

210201	Тэтгэврийн даатгал	11,257,028.00	13,833,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,374,500.00	1,627,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,099,600.00	1,301,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	309,600.00	325,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	35,731,200.00	37,153,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	156,169,219.00	173,515,882.00
210301	Гэрэл, цахилгаан	20,008,916.00	15,854,127.00
210302	Түлш, халаалт	134,455,657.00	155,713,959.00
210303	Цэвэр, бохир ус	1,704,646.00	1,947,796.00
2104	Хангамж, бараа материалын зардал	104,488,548.00	17,313,888.00
210401	Бичиг хэрэг	4,056,800.00	4,206,500.00
210402	Тээвэр, шатахуун	92,630,600.00	5,671,358.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	4,912,548.00	4,155,230.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	2,888,600.00	3,280,800.00
2105	Нормативт зардал	70,270,200.00	65,728,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,062,200.00	1,335,100.00
210502	Хоол, хүнс	69,208,000.00	64,393,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	69,441,100.00	115,317,907.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	420,400.00	0.00
210604	Урсгал засвар	69,020,700.00	115,317,907.00
2107	Томилолт, зочны зардал	115,485,500.00	37,644,000.00
210702	Дотоод албан томилолт	115,485,500.00	37,644,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	28,087,677.00	17,778,447.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,463,000.00	813,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	806,400.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,693,900.00	1,693,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	893,704.00	1,095,676.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	638,000.00	649,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,667,200.00	1,667,200.00
210807	Газрын төлбөр	16,925,473.00	11,052,971.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	41,536,620.00	9,503,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	34,341,520.00	2,700,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	7,195,100.00	6,803,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	23,327,086.00	16,118,057.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	11,053,304.00	12,434,309.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	11,053,304.00	12,434,309.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	12,273,782.00	3,683,748.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	12,225,631.00	3,683,748.00
213305	Нэмэлт санхүүжилт төвлөрүүлэх шилжүүлэг	48,151.00	0.00
III	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(I)-(II)	75,019,800.00	69,841,800.00
V	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (V)	75,019,800.00	69,841,800.00
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	75,019,800.00	69,841,800.00
2200	Дотоод эх үүсвэрээр	75,019,800.00	69,841,800.00
223001	Бусад хөрөнгө	30,000,000.00	0.00
225106	Биет ба биет бус хөрөнгө худалдан авсан зардал	45,019,800.00	69,841,800.00
VI	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VI)=(IV)-(V)	-75,019,800.00	-69,841,800.00

VIII	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (VIII)=(III)+(VI)+(VII)	0.00	0.00
101	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	0.00	0.00
20	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	0.00	0.00

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
1	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,543,338,689.6	543,765,736.2	5,212,895,574.5	7,300,000,000.2
2	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
3	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,543,338,689.6	543,765,736.2	5,212,895,574.5	7,300,000,000.2
4	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
5	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
6	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0
7	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
8	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
9	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	479,540,517.3	479,540,517.3
10	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,543,338,689.6	543,765,736.2	5,692,436,091.7	7,779,540,517.5
11	2022 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл	1,543,338,689.6	543,765,736.2	5,692,436,091.7	7,779,540,517.5
12	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
13	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	1,543,338,689.6	543,765,736.2	5,692,436,091.7	7,779,540,517.5
14	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
15	Үндсэн хөрөнгийн өсөлт бууралт	0.0	0.0	0.0	0.0
16	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.0	0.0	0.0	0.0
17	Өмчид гарсан өөрчлөлт	0.0	0.0	0.0	0.0
18	Зарласан ногдол ашиг	0.0	0.0	0.0	0.0
19	Тайлант үеийн үр дүн	0.0	0.0	-402,238,956.3	-402,238,956.3
20	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	1,543,338,689.6	543,765,736.2	5,290,197,135.5	7,377,301,561.2

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Код	Үзүүлэлт	Төлөвлөгөө	Төсвийн гүйцэтгэлийн тайлан
II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	2,088,783,900.00	2,085,100,152.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	2,088,783,900.00	2,085,100,152.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	2,083,907,500.00	2,080,228,552.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	1,695,498,600.00	1,695,037,723.00
210101	Үндсэн цалин	983,471,100.00	983,010,223.00
210102	Нэмэгдэл	667,477,300.00	667,477,300.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	44,550,200.00	44,550,200.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	54,242,000.00	54,242,000.00
210201	Тэтгэврийн даатгал	13,833,100.00	13,833,100.00
210202	Тэтгэмжийн даатгал	1,627,500.00	1,627,500.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	1,301,900.00	1,301,900.00
210204	Ажилгүйдлийн даатгал	325,600.00	325,600.00
210205	Эрүүл мэндийн даатгал	37,153,900.00	37,153,900.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	173,579,900.00	173,515,882.00
210301	Гэрэл, цахилгаан	31,446,900.00	15,854,127.00
210302	Түлш, халаалт	139,425,000.00	155,713,959.00
210303	Цэвэр, бохир ус	2,708,000.00	1,947,796.00
2104	Хангамж, бараа материалын зардал	14,950,200.00	14,950,200.00
210401	Бичиг хэрэг	4,031,500.00	4,031,500.00
210402	Тээвэр, шатахуун	4,000,000.00	4,000,000.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	3,637,900.00	3,637,900.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	3,280,800.00	3,280,800.00
2105	Нормативт зардал	62,488,100.00	62,488,100.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	1,335,100.00	1,335,100.00
210502	Хоол, хүнс	61,153,000.00	61,153,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	49,446,800.00	49,446,800.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	2,441,800.00	2,441,800.00
210604	Урсгал засвар	47,005,000.00	47,005,000.00
2107	Томилолт, зочны зардал	5,791,900.00	5,766,000.00
210702	Дотоод албан томилолт	5,791,900.00	5,766,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	20,906,600.00	17,778,447.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	985,800.00	813,300.00
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	1,116,000.00	806,400.00
210803	Даатгалын үйлчилгээ	1,693,900.00	1,693,900.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	2,423,900.00	1,095,676.00
210805	Тээврийн хэрэгслийн оношилгоо	1,042,300.00	649,000.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	1,667,200.00	1,667,200.00
210807	Газрын төлбөр	11,977,500.00	11,052,971.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	7,003,400.00	7,003,400.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	200,000.00	200,000.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	6,803,400.00	6,803,400.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	4,876,400.00	4,871,600.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	4,876,400.00	4,871,600.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	4,876,400.00	4,871,600.00
III	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	2,088,783,900.00	2,085,100,152.00
31	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	2,088,783,900.00	2,085,100,152.00
310001	Улсын төсвөөс санхүүжих	2,088,783,900.00	2,085,100,152.00



2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

II	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	183,257,304.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	183,257,304.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	175,694,595.00
2104	Хангамж, бараа материалын зардал	2,363,688.00
210401	Бичиг хэрэг	175,000.00
210402	Тээвэр, шатахуун	1,671,358.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	517,330.00
2105	Нормативт зардал	3,240,000.00
210502	Хоол, хүнс	3,240,000.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	135,712,907.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	52,600,000.00
210602	Тавилга	83,112,907.00
2107	Томилолт, зочны зардал	31,878,000.00
210701	Гадаад албан томилолт	31,878,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,500,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	7,562,709.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	7,562,709.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	7,562,709.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	7,562,709.00
I	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	183,257,304.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	183,257,304.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	40,105,039.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	142,977,265.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	175,000.00

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Онцгой байдлын газар нь гамшгаас урьдчилан сэргийлэх, гамшиг, осол, гал түймрийн эрсдэлийг бууруулах, авран хамгаалах гэсэн зорилгын дор үйл ажиллагааны чиглэл зорилтоо тодорхойлон ажиллажээ.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд дараах өөрчлөлтүүд орсон байна. Үүнд:

- ✓ Хөдөлмөрийн тухай хууль - Шинэчлэн найруулгыг 2022 оны 01 сарын 01-ний өдрөөс мөрдөж эхэлсэн.
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль -2022 оны 04 дүгээр сарын 29-ний өдөр батлагдсан.



- ✓ Төрийн албаны тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ны өдөр, 7 дугаар сарын 05-ны өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр нэмэлт өөрчлөлтүүд оруулсан байна.
- ✓ Төсвийн тухай хуульд 2022 оны 4 дүгээр сарын 22-ний өдөр, 7 дугаар сарын 01-ний өдөр, 8 дугаар сарын 29-ний өдөр, 11 дүгээр сарын 11-ний өдөр тус тус нэмэлт өөрчлөлт оруулсан байна.

Байгууллагын удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Төсвийн ерөнхийлөн захирагчаас эрсдэлд суурилсан дотоод аудит хийгээгүй байна.

Дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруэл сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Тус байгууллагын мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайланг Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогод өөрчлөлт ороогүй байна.

Увс аймгийн Онцгой байдлын газрын 2022 оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 380,034.2 мянган төгрөгөөр буюу 4.8 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөг/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө			
Авлага			
Урьдчилгаа			
Бараа материал	1,055,526.4	1,249,549.1	194,022.7
Үндсэн хөрөнгө	6,724,014.1	6,149,957.2	-574,056.9
Нийт хөрөнгө	7,779,540.5	7,399,506.3	-380,034.2
Өр төлбөр		22,204.8	22,204.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	7,779,540.5	7,377,301.6	-402,238.9
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	7,779,540.5	7,399,506.3	-380,034.2

Бараа материалын дансны үлдэгдэл 1,249,549.1 мянган төгрөг болж 194,022.7 мянган төгрөгөөр өссөн нь хангалтаар ирсэн бараа материалыг орлогод авснаас шалтгаалжээ.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 6,149,957.2 мянган төгрөг болж 574,056.9 мянган төгрөгөөр буурсан нь үндсэн хөрөнгийн дансны хөрөнгийн элэгдэл өссөнөөс шалтгаалжээ. Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 69,841.8 мянга, хандиваар болон үнэ төлбөргүй шилжиж ирсэн 142,138.7 мянган төгрөгөөр нэмэгдсэн ч үндсэн хөрөнгийн элэгдэл 786,037.4 мянган төгрөгөөр өссөн байна.

Өр төлбөр 22,204.8 мянган төгрөгөөр өссөн нь тээвэр шатахууны өр төлбөр нэмэгдсэнээс шалтгаалжээ.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 7,377,301.6 мянган төгрөг болж 402,238.9 мянган төгрөгөөр буурсан нь тайлант оны үр дүн буурснаас шалтгаалжээ.

Өмчийн өөрчлөлтийн тайлангаар нягтлан бодох бүртгэлийн залруулга хийгдээгүй байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Онцгой байдлын газрын 2022 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 2,722,214.7 мянган төгрөгөөр, нийт зарлагыг 2,722,214.7 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслөөс 633,430.8 мянган төгрөгөөр бууруулж 2,088,783.9 мянган төгрөгөөр баталсан байна.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх хөтөлбөр, арга хэмжээг санхүүжүүлэхээр 2,088,783.9 мянган төгрөгийн төсөв баталснаас 2,088,783.9 мянган төгрөгийг улсын төсвөөс санхүүжүүлэхээр төлөвлөжээ.



Гүйцэтгэлээр улсын төсвөөс 2,088,783.9 мянган төгрөгийн санхүүжилт авч нийт 2,088,783.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 2,085,100.2 мянган төгрөгийг зарцуулж 3,683.7 мянган төгрөгийг төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 2,085,100.2 мянган төгрөг буюу 99.8 хувьтай байгаа нь зардлыг 3,683.7 мянган төгрөгөөр хэмнэсэнтэй холбоотой байна.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
1	70708-Гамшгаас урьдчилан сэргийлэх 80101-Үндсэн үйл ажиллагааны зардал	2,083,907.5	2,083,907.5	0	100 %
2	70708-Гамшгаас урьдчилан сэргийлэх 80802-Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал	4,876.4	4,876.4	0	100 %
Дүн		2,088,783.9	2,088,783.9	0	100 %

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Орон нутгийн төсвөөс 40,105.0 мянга, дээд шатны төсвийн захирагчаас 142,977.3 мянга, үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого 175.0 мянга, нийт 183,257.3 мянган төгрөгийн орлогыг бүрдүүлжээ.

Үүнээс бичиг хэргийн зардалд 175.0 мянга, тээвэр шатахууны зардалд 1,671.4 мянга, шуудан холбооны зардалд 517.3 мянга, хоол хүнсний зардалд 3,240.0 мянга, багаж, техник хэрэгслийн зардалд 52,600.0 мянга, урсгал засварын зардалд 83,112.9 дотоод албан томилолтын зардалд 31,878.0 мянга, бараа үйлчилгээний бусад зардалд 2,500.0 мянга, нэг удаагийн мөнгөн тэтгэмжийн урамшууллын зардалд 7,562.7 мянган төгрөгийг зарцуулсан байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.


3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант хугацаанд төсөл хөтөлбөр хэрэгжүүлээгүй байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан



гаргана” гэж заасны дагуу Онцгой байдлын газрын 2022 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Увс аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор Б.Авирмэд гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер М.Бат-Амгалан, дарга, тэргүүлэх аудитор М.Батсуурь нар тус тус хэрэгжүүлсэн.

Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Увс аймаг дахь Төрийн аудитын газарт 2023 оны 01 дүгээр сарын 13-ны өдрийн 34/16 дугаар албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр нийт зардлыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл дунд гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.0 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн үе шатанд материаллаг байдлыг 2021 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардлаар тооцож 26.4 сая төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж шинэчлэн тогтоох шаардлагатай гэж үзсэн. Гүйцэтгэлийн үе шатанд 2022 оны санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зардал 3,191.9 сая төгрөгийн 1.0 хувь буюу 31.9 сая төгрөгөөс 80 хувиар тооцож 25.5 сая төгрөгөөр тогтоолоо.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Төрийн хэмнэлтийн тухай хууль хэрэгжиж эхэлсэнтэй холбоотойгоор Онцгой байдлын газрын тухайн хуульд хамаарах зүйл заалтын хүрээнд горим сорил хэрэгжүүлсэн. Төрийн хэмнэлтийн тухай хуулийг хэрэгжүүлэн ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга,



нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд www.shilendans.gov.mn цахим хуудсанд оруулбал зохих 151 мэдээллээс хугацаандаа оруулсан 149, хугацаа болоогүй хүлээгдэж байгаа 2 мэдээлэл байна.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Онцгой байдлын газрын 2022 оны санхүүгийн тайланд завсрын аудит хийгээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх оны санхүүгийн тайлангийн аудитаар зөвлөмж өгөгдөөгүй байна.

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй байна.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар зөрчил илрээгүй болно.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

АУДИТЫН ТАЙЛАНГ

ХЯНАСАН:

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР  /М.БАТСУУРЫ/

АУДИТЫН МЕНЕЖЕР /М.БАТ-АМГАЛАН/

БЭЛТГЭСЭН:

АХЛАХ АУДИТОР  /Б.АВИРМЭД/

2023 оны 02 сарын 08-ны өдөр

